



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар A/81

Жаргалтхаан

Газар эзэмших эрхийг өвлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигч иргэн Шаравдоржийн Гантөгс (СМ85100611) нь нас барсан тул Жаргалтхаан сумын 1-р баг, Цагаан шовх хаягт орших, 2319002326 нэгж талбарын дугаартай, өвөлжөө хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг түүний өвлөгч Энхтуяагийн Ганчимэг (СР85020800)-т өвлүүлсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмших эрх өвлөгчид даалгасугай.

3.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/75 дугаар захирамжийн хавсралтын холбогдох хэсэг, Ш.Гантөгсийн эзэмшлийн 000445479 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

• 232401187